



# СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

## БХЯ МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА



Батлан хамгаалах яам болон "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах ажиллагаа өчигдөр БХЯ-нд боллоо.

Манай улс сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх төмөр зам, авто зам, газрын тосны үйлдвэр зэрэг стратегийн томоохон бүтээн байгуулалтыг дотоодын ажиллах хүчний оролцоотойгоор барьж байгуулах ажлыг эрчимтэй хэрэгжүүлж байгаа билээ. Дээрх стратегийн бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн анги, салбарууд идэвхтэй оролцож төр засгаас даалгасан үүргийг богино хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэж буй. Энэхүү санамж бичгийг байгуулснаар төр-хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн гадаад дотоодын арга хэмжээ, хамтын ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгох, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн барилга, зам, гүүр, төмөр зам зэрэг стратегийн бүтээн байгуулалтын ажлын оролцоог эрчимжүүлэх, хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Мөн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хамтарсан сургалтыг зохион байгуулах, орчин нөхцөлийг нь бүрдүүлэх, офицер, ахлагч, алба хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм. Түүнчлэн орон нутагт байрлах цэргийн анги, салбарын барилга инженерийн дэд бүтцийг сайжруулах, эрчим хүчийг хэмнэх, алдагдлыг бууруулах, дулааны үр ашгийг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, оновчтой, үр ашигтай шийдэл гаргах, саарал усыг дахин ашиглах, ногоон технологийг нэвтрүүлэх замаар гүний цэнгэг усны хэрэглээг хэмнэх, ундаргыг нь тэтгэх зэрэг үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Тус арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг, УИХ-ын гишүүн, "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-ын дэд ерөнхийлөгч Д.Өнөрболор, "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-ын ерөнхийлөгч Д.Цэрэнжигмэд болон БХЯ, ЗХЖШ-ын удирдлага, албаны бусад хүмүүс байлцлаа.

## ХОЁР ОРНЫ БАТЛАН ХАМГААЛАХ ХАРИЛЦАА ЦААШИД ИЛҮҮ ИДЭВХЖИНЭ



Батлан хамгаалах яам "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагааны дараа Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр УИХ-ын гишүүн Р.Өнөрболор, Т.Доржханд нарыг хүлээн авч уулзлаа.

Монгол, Катар хоёр орон олон улсын түвшинд үүсээд буй терроризмыг идэвхтэй сөрөн зогсоож буй эвсэлд нэгдэж, нийтлэг эрх ашгийн төлөө хамтран ажиллаж байгаа билээ. Мөн хоёр орны Батлан хамгаалах салбарын харилцаа сүүлийн жилүүдэд нэлээд идэвхжих

хандлагатай байгаатай холбогдуулж, энэ удаагийн уулзалтаар салбарын харилцаа, хамтын ажиллагааны талаар харилцан ярилцлаа. Түүнчлэн манай хоёр орны батлан хамгаалах салбарын цаашдын харилцаа, энхийг дэмжих, тусгай хүчний болон байгалийн гамшигтай тэмцэх ажиллагаа, цэргийн алба хаагчдыг сургах чиглэлээр улам илүү идэвхтэй хамтран ажиллах талаар харилцан санал солилцов.

УИХ-ын гишүүн Р.Өнөрболор нь парламент дахь Монгол, Катарын харилцааны бүлгэмийн дарга бол УИХ-ын гишүүн Т.Доржханд нь тус бүлгэмийн гишүүн юм.

## Г.Сайханбаяр: ХАРИЛЦАА ХАНДЛАГА ТАЛ ДЭЭР ЭРГЭЛТ ГАРГАХ ЦАГ НЬ БОЛСОН

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өчигдөр цаг үеийн асуудлаар Төрийн цэргийн командлалуудын удирдлага, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нартай цахим хурал хийж, цэргийн албаны сахилга хариуцлага, дэг журам, ёс зүйн

Тиймээс цэргийн албаны харилцаа зөвхөн дүрмийн хүрээнд явагдах бөгөөд үг, үйлдлээрээ үргэлж зөв байх ёстой болохоос дүрмийн бус харилцаа үүгээр эцэс болох ёстой.

Дараагийн дугаарт ажлын байран дээрх архидалттай ямар ч шатны дарга нар эвлэрч болохгүй.



чиглэлээр холбогдох үүрэг даалгавар өглөө.

Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд цэргийн алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажиллахыг үүрэг болголоо. Нийгмийн толь байх ёстой салбар ганц нэг хүний хариуцлагагүй үйлдлээс болж цахим сүлжээгээр салбараараа "цоллуулж" байна. Тиймээс бид бүхэн харилцаа, хандлага, сэтгэлгээгээ өөрчилж, сахилга, хариуцлага нэмэгдүүлэх шаардлагатай. Цэргийн нэгтгэл, анги, салбарт дотоод хяналт шалгалтыг даруй явуулж цэргүүдтэй ажилладаг анхан шатны захирагч дарга, бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, эрэлт хэрэгцээг мэдэрч, хэн нэгэнд хариуцлага тооцох бус урьдчилан сэргийлэхийн тулд судалгаа, бодит үнэлгээнд тулгуурладаг байхыг анхаарууллаа.

Цэргийн алба хаагчдын харилцаа, албаны хандлага, хувь хүний хөгжил, нийгмийн эрх зүйн соёл, ухамсар төлөвшилт тал дээр нэгтгэл, анги салбар, бие бүрэлдэхүүн бүр бодитоор анхаарахгүй бол бид бодлого яриад, мянган ажил хийгээд ухамсаргүй нэгний балгаар салбараараа шороотой хутгалдаж байна. Энэ бол нэг үхрийн эвэр доргиод мянган үхрийн эвэр доргиож байгаа бодит жишээ. Хугацаат цэргийн алба хаагчид бол тухайн ангийн толь байх ёстой.

Хэдийгээр Зэвсэгт хүчний хүрээнд ажлын байран дээр архидал сонгуурах асуудал хумигдсан ч гэсэн урьдчилан сэргийлж байх ёстой. Ажлын байр бус, ахуйн хүрээнд ч асуудал гаргаж болохгүй хэмээн санууллаа.

Төгсгөлд нь улсын хэмжээнд цар тахлын халдварын тархалт өдрөөс өдөрт нэмэгдэж буйтай холбогдуулж, Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамны заавар зөвлөмжийг ягштал мөрдөхийн зэрэгцээ нэгтгэл, ангиуд бие бүрэлдэхүүнийхээ тоог аль болох цөөлж, гэрээрээ ажиллаж байгаа тохиолдолд хяналт тавьж ажиллахыг анхааруулав. Ажлын байрны ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, дотогш нэвтрэх тохиолдолд PCR шинжилгээ өгч байхын зэрэгцээ вакцин хийлгэсэн алба хаагчдад ч энэ заавар зөвлөмж хамаатай гэв. Түүнчлэн хөл хорионы үед алба хаагчдынхаа нийгмийн асуудалд анхаарч, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд холбогдох албан тушаалтнууд хяналт тавьж ажиллахыг үүрэг болголоо.

Цахим хуралд ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа З.Болдбаатар нар байлцлаа.

ТАНЫ СОНОРТ

## "СОЁМБО" СОНИНЫ ШИНЭ ДУГААРТ ...

Эрхэмуншигч Та Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний "Соёмбо" редакцияас долоо хоног тутам эрхлэн гаргадаг "Соёмбо" сонины 13 дахь дугаараас БХЯ-ны СБТГ-ын Батлан хамгаалах бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Д.Дашзэвэг "Цэргийн багийн бүрэлдэхүүнээс англи хэлний шалгалт авна" ярилцлагыг уншаарай. Танд "Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах журам", "Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам" батлагдсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүргэнэ.

Мөн ЗХЖШ-ын БСТГ-ын даргын орлогч, Цэргийн бодлогын хэлтсийн дарга, хурандаа Ш.Амарбаясгалантай

хийсэн "Бие бүрэлдэхүүнийг чадваржуулж, хөгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ" ярилцлагыг хүлээн авч уншаарай. Энэхүү ярилцлагаар 2021 онд салбарын хэмжээнд хийгдэх томоохон ажлууд болон улс орны бүтээн байгуулалт, энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчнийг цаашид хэрхэн оролцуулах зэрэг чухал сэдвүүдийг хөндлөө.

Дэлхийн халуун цэгт үүрэг гүйцэтгэж буй монгол цэргүүдээ ажиллагааны газар оронд нь очиж сурвалжилсан анхны сэтгүүлч И.Буянжаргалтай хийсэн ярилцлага багтсаны зэрэгцээ "Цэргийн" гэж өмчилмөөр содон нэртэй эрхмүүдийн талаархи сонирхолтой мэдээллийг уншаарай.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
8°C	-0°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39°C	26°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
17°C	1°C

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,332.0	3,397.0
CNY	433.40	437.70
RUB	36.66	38.42
JPY	25.82	26.45
KRW	2.45	2.58

### КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	481
НИЙТ БҮРТГЭГДСЭН	8070
ЭДГЭРСЭН	4835
НАС БАРСАН	10

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	54
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	274
ЭДГЭРСЭН	1137
НИЙТ БАТЛАГДСАН	1413

### ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.31

/ЛХАГВА ГАРАГ/

**ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН НАЙМАН ЦАГААН ШАР БАР ӨДӨР**

**Үс засуулвал: ЭД МАЛЫН ГАРЛАГАТАЙ Наран ургах, шингэх: 06.33-19.20**

**Барилдлага: ҮХЭХ**

**Шүтэн барилдлага: МУНХРАХУЙ**

**Суудал: ТӨМӨР**

Аргын тооллын 3 сарын 31, Буд гараг. Билгийн тооллын 18, Хонгорцог одтой, шар бар өдөр. Өдрийн наран 6 цаг 33 минутад мандан, 19 цаг 20 минутад жаргана. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, сэтгэлд сэтгэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсоод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЦАХИМ ШУУДАНД

## ШИНЭ ХҮНЭЭ ШИНЭ ГЭРТ УГТАН АВЛАА



Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 110 дугаар анги “Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан ангийн бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Барилгын материал үйлдвэрлэлийн ротын салааны ахлагч, ахлах ахлагч Б.Лхагва-Эрдэнэд өргөө цагаан гэр, 4 тал хашаа, 0.7 га газрын гэрчилгээний хамт бэлэглэлээ.

Энэ үеэр ахлах ахлагч Б.Лхагва-Эрдэнэ шинэ хүнээ өлгийдөн аваад удаагүй байсан бөгөөд шинэ хүнээ өргөө цагаан гэртээ угтсан ховорхон тохиол болов.

## ЦАХИМ ГҮЙЛТИЙН АВАРГА ТОДРОВ

Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан энэ сарын 15-28-ны өдрүүдэд улс орон даяар зохион байгуулсан “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” аянд Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн ажиллагааны ахлагч, тэргүүн ахлагч Б.Баттулга амжилттай оролцлоо.

Тэрээр гэр бүлийн хамт өөрсдийгөө ялах зорилгоор оролцсон бөгөөд Налайх дүүргээс оролцсон 350 оролцогчоос эрэгтэй төрөлд тэргүүн ахлагч Б.Баттулга 610 км, эмэгтэй төрөлд эхнэр Б.Одгэрэл 377 км замыг туулж, тэргүүн байрыг тус тус эзэлсэн аж. Тэмцээний турш тэд өдөрт дунджаар 43.5 км гүйсэн байна.



Ахлах дэслэгч М.ОЧГЭРЭЛ

100 ЖИЛД

## ЭР ХҮН БОЛЖ ТӨРӨХ НЬ ТАВИЛАНГИЙНХ, ХАРИН ЭР ХҮН БОЛЖ АМЬДРАХ НЬ СОНГОЛТЫНХ



Монгол цэргийн нэгдсэн холбоо, “Отгонтэнгэр” их сургууль хамтран ЕБС-иудын төгсөх ангийн сурагчдын дунд “Эрхмийн дээд-Монгол эр хүн” эсээ бичлэгийн цахим уралдаан зарлан дүгнэлээ.

Уралдаанд 19 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын 3000 гаруй сурагч анхан шатны шалгаруулалтад оролцож, эсээгээ ирүүлснээс 240 сурагчийн ажлыг 2, 3 дугаар шатанд шалгаруулж цуваагаар 15 байр эзлүүлэн дүгнэсэн юм. Орчин үеийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн түүхт ойн үеэр эрт, эдүгээгийн монгол эрчүүдийн тухай тал бүрээс нь эргэцүүлэн бодож, шүүн тунгааж, эх орныхоо аюулгүй байдал, төр улсынхаа тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалж, хүн ардынхаа энхийн манаанд түүчээлэн зүтгэж, эх орныхоо хөгжил дэвшлийн бүтээн байгуулалтад манлайлж яваа өнөө үеийн эрчүүдийн тухай өсвөр үеийн хөвгүүд охидын сэтгэлийн үгийг өргөн олон нийтэд толилуулахын учир энэхүү ажлыг сэдсэн юм. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид үе үеийн монгол эр хүний эрхэмлэн дээдэлж ирсэн сэтгэл зүй-ёс суртахуун, гоо сайхан, нийгэм, улс төрийн үзэл

итгэл, үнэмшлийн үнэт зүйлсийг олон талааснь анхааран үзэж өөрсдийнхөө эсээд дурдаж зарим хэсэг нь бүр урнаар дүрслэн үзүүлсэн байна. Жишээлбэл, Дархан-Уул аймгийн 16 дугаар сургуулийн 12в ангийн сурагч Б.Хонгорзул “Тэртээх 13 дугаар зуунд улс орон төвхнөөгүй, үндэстэн бүгдээр тархай бутархай байсан цаг үед эвдрэлцсэн цэрэг эрсийг буцаан эвлэрүүлж, Их Монгол Улсыг бүтээн цогцлоосон эзэн Чингис хаан, түм буман цэргийг ур ухаанаараа удирдаж, дэлхийг дэвэргэж, түүхийг эзэгнэсэн монгол эр хүнээс энэ улсын бөгөөд дэлхийн түүх эхтэй билээ” хэмээн эх түүхээрээ бахархсан байх юм.

Эсээ уралдаанд оролцсон сурагчийн бараг тал хувь нь өөрсдийн өвөө, аавыг бахархан дууриадаг, амьдралын минь өмөг түшиг болдог, үг сургаалаа харамгүй хайрлаж, өсөх насны минь зан чанарын чиг баримжаа болдог эрхэм хүмүүс хэмээн үздгээ илэрхийлсэн байв. Тухайлбал, нийслэлийн “Эрдмийн оргил” цогцолбор сургуулийн 12в ангийн сурагч Г.Мөнхдөл “Манай гэрт ааваас минь илүү эрхэмсэг, тэнгэрлэг нэр хүндтэй, эрч хүчтэй, энгийн мөртлөө хүндлэл, бичрэл төрүүлсэн хал нь гаднаа хайр нь дотроо, халамж энэрлийн ундарга болсон хүн байхгүй. Халуу дүүгсэн гэртээ аав минь байхад гэр дүүрээд

бид жаргалтай, өмөг түшигтэй бүх юм эмх цэгцтэй болчихсон юм шиг санагддаг. Аавын минь халамж анхаарал, эр хүний уужуу тайван ухаан, өгөөмөр их хайр, хөдөлмөр, эв эийг эрхэмлэдэг зан чанар, ядарч зовсон хүнд тусламж дэмжлэг үзүүлдэг өр зөөлөн сэтгэл, өөрийн биеэр үлгэрлэж ажилладаг манлайлах ур чадвар, ахмад хүмүүсийг хүндэтгэж, үг сургаалыг нь сонсож амьдралдаа хэрэгжүүлдэг дадал, улс нийгмийн өмнө хүлээсэн ажил үүргээ үнэнчээр биелүүлдэг үлгэр дууриал нь бидэнд нөлөөлж байдаг. Аав, эх орноо хайрлах, эх орондоо хүчээ өгч, эх орноороо бахархаж, тусгаар Монгол орноо мандуулан хөгжүүлж, асар их үнээр олдсон тусгаар тогтнол, газар шороогоо нүдний цөцгий мэт хайрлаж явахыг бидэнд захидаг” гэж бичсэн байх юм.

Чингэлтэй дүүргийн 61 дугаар сургуулийн 12в ангийн сурагч Б.Хулангийн “Эр хүн болж төрөх нь тавилангийнх, харин эр хүн болж амьдрах нь сонголтынх. Аав эсвэл хань гэх алдрын ард амьдралыг манлайлах, зөв амьдарч, зөвд чиглүүлэх үүрэг байдаг” гэсэн ончтой, ухаалаг үгээр энэхүү тоймоо өндөрлөө.

Доктор, профессор  
Б.ГАЛИНДЭВ

ЦАГ УЕ

## ХӨЛ ХОРИО ТОГТООХГҮЙ БОЛ КОРОНАВИРУСИЙН ТАРХАЛТ 10 ДАХИН НЭМЭГДЭНЭ



Дэлхийн эмч нарын баярын өдрөөр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвд ажиллав.

Энэ үеэр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ цар тахалтай тэргүүн эгнээнд нүүр тулан, эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнуудад Засгийн газраас нийт 2.8 тэрбум төгрөгийн дэмжлэгийг олгох болсон талаар мэдээлэл хийлээ. Тодруулбал, КОВИД19-ийн эсрэг ажиллаж байгаа 2230 эмч, эмнэлгийн ажилчдад нэг сая төгрөгийн, 1100 резидент эмч тус бүрт 500 мянган төгрөгийн нийт 2.8 тэрбум төгрөгийн урамшуулал олгох бөгөөд энэ асуудлыг өнөөдөр болох Засгийн газрын ээлжит хуралдаанаар эцэслэн шийдвэрлэх юм.

Мөн Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ХӨСҮТ-д тулгамдаж байгаа зарим асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Сангийн сайд Б.Жавхлан нарт чиглэл болголоо. Амаргүй цаг үед хамтын хүчээр цар тахлыг даван туулж, Засгийн газраас эрүүл мэндийн салбарынхаа алба хаагчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөл, цалин хөлсний асуудалд үе шаттайгаар анхаарч, хамтран ажиллах болно

гэдгийг хэлсэн юм.

Хавдар судлалын үндэсний төв энэ сарын 26-ны өдрөөс эхлэн хавдартай иргэдийг Пфайзер вакцинаар дархлаажуулж эхэлсэн бөгөөд вакцинд хамрагдуулалт хэрхэн явагдаж байгаатай Ерөнхий сайд энэ үеэр танилцав. Мөн “Ковакс” хөтөлбөрийн хүрээнд манай улсад хандивласан 25.740 тун Пфайзер вакцины тухайд эрхтэн шилжүүлэн суулгасан, архаг хууч өвчтэй, хавдартай иргэдэд тус вакциныг хийж эхлээд байгаа юм.

Хавдар судлалын үндэсний төвийн эмч нарын мэдээллээр вакцинжуулалтад хамрагдсан иргэдээс сөрөг урвал ажиглагдсан тохиолдол байхгүй, өвчтөнүүдийн биеийн байдал хэвийн, эмчийн хяналтад байгаа гэлээ.

ХСҮТ-д ажилласны дараа Ерөнхий сайд Халдварт өвчин судлалын үндэсний төвд ажиллав. Тус төвийн Ерөнхий захирал Л.Баттөр коронавирусийн тархалт болон одоогийн нөхцөл байдлын талаар товч мэдээлэл хийсэн бөгөөд тэрбээр хөл хорио тогтоохгүй бол коронавирусийн тархалт зургаадугаар сарын дунд үед одоогийнхоос 10 дахин нэмэгдэх тооцооллыг танилцуулсан юм.

## НӨӨЦИЙН МАХЫГ ХҮНСНИЙ 405 ДЭЛГҮҮРЭЭР БОРЛУУЛНА



Нөөцийн махны худалдааг энэ сарын 26-наас эхлүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр болон Нийслэлийн Татварын газрын дарга Б.Цогтнарар, Нийслэлийн Мал эмнэлгийн Хяналт, эрсдэлийн үнэлгээний хэлтсийн дарга Д.Доржсүрэн нар өчигдөр мэдээлэл хийлээ.

Жил бүр зохион байгуулдаг мал, мах бэлтгэн нөөцлөх, худалдан борлуулах ажлын хүрээнд “Мах импэкс” ХК, “ХКУ”, “Баатарууд тэнгэр”, “Дархан мөст фүүдс”, “Эй Эн Ди Эм”, “Нүүдэлчин мах маркет”, “Траст трейд”, “Комит сервис”, “Агро нэгтгэл трейд”, “Цалуут импэкс”, “Соотон”, “Эко фүүдс трейд”, “Эрдэнэт хүнс”, “Цэц

манхан”, “Булган мах маркет”, “Ару дана”, “Азат” ХХК зэрэг 17 аж ахуйн нэгж арилжааны банкны зээлийн эх үүсвэрээр 11 мянган тонн мах бэлтгэж нөөцөлжээ.

Энэ жил зорилтот бүлгийн хүн ам, өрхийн тоо, байршилд шаардлага хангасан хөргүүр, хөлдөөгч, Е баримт хэвлэгч пост терминаль төхөөрөмж зэргийг харгалзан нийслэлийн хэмжээнд нөөцийн махыг 405 хүнсний дэлгүүрээр худалдаална. Мөн Татварын газартай хамтран Е-баримт хэвлэгч пост терминалийн төхөөрөмж суурилуулж, хүнсний дэлгүүрүүдтэй “Агентийн гэрээ” байгуулах замаар НӨАТ-аас чөлөөлж, худалдан авагчдад сугалааны дугаар бүхий Е-баримт олгох асуудлыг шийдвэрлэсэн байна.



**СОЁМБО СОНИН**  
“Соёмбо” сонин 97 дахь жилдээ  
хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАЛАМБА,  
Д.НАЦАДОРЖ

Дарга, ерөнхий  
редактор  
Хурандаа  
САНЖМЯТАВЫН  
ТӨМӨРХУЯГ

Эхийг “Соёмбо”  
сонини редакцал  
бэлтгэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл бодол сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс 10018  
И-мэйл хаяг:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029